

**“Валютаар хийгдсэн санхүүгийн түрээсийн гэрээний хэрэгжилтийг дүгнэх
аргачлалыг EXCEL программд тулгуурлан боловсруулах”
гэрээт ажлын урилга**

Зорилго: Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 2017 оноос эхлэн иргэн, аж ахуйн нэгжүүдтэй төлбөрийг валютаар гүйцэтгэх нөхцөлөөр байгуулсан Санхүүгийн түрээсийн гэрээний хэрэгжилтийг EXCEL программ ашиглан дүгнэх аргачлал /Цаашид “гэрээт ажил” гэх/-ыг боловсруулах

Гэрээт ажлын даалгавар хамрах хүрээ:

ХААДС-аас санхүүжүүлэгчтэй байгуулсан 4 удаагийн гэрээний тус бүр 5 хэрэглэгчийн гэрээ, гэрээний үүргийн хэрэгжилт болон бусад мэдээллийг ашиглана.

Гэрээт ажил нь дараах хэрэглэгчдэд зориулагдсан байна.

1. Худалдан авагч: /Харилцагч тус бүрээр/

1.1. Зээлийн төлбөрийн барагдуулалт, үлдэгдэл /Хугацаа хэтэрсэн болон хугацаандаа ангиллаар/

1.2. Хүүгийн төлбөр барагдуулалт, үлдэгдэл /Авлага, өглөг нь Хугацааны ангиллаар/

1.3. Гэрээний үүргийн хэрэгжилтээс хамааран хүүгийн төлбөрт гарах өсөлт, бууралт

1.4. Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийн алданги

1.5. Валютын ханшийн зөрүүний олз, гарз

2. Санхүүжүүлэгч байгууллага: /Санхүүгийн түрээсийн гэрээ тус бүрээр/

2.1. Зээлийн төлбөрийн барагдуулалт, үлдэгдэл /Хугацаа хэтэрсэн болон хугацаандаа ангиллаар/

2.2. Хүүгийн төлбөр барагдуулалт, үлдэгдэл/Авлага, өглөг нь Хугацааны ангиллаар/

2.3. Гэрээний үүргийн хэрэгжилтээс хамааран хүүгийн төлбөрт гарах өсөлт, бууралт

2.4. Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийн алданги

2.5. Валютын ханшийн зөрүүний олз, гарз

3. Хөдөө аж ахуйг дэмжих сан: /Нэгдсэн тайлан хэлбэрээр/

3.1. Бараа материалын хөдөлгөөний тайлан

3.2. Харилцагч талуутай холбогдох зээлийн тайлан /Авлага, өглөг нь Хугацааны ангиллаар/

3.3. Хүүгийн авлага, өглөг /Авлага, өглөг нь Хугацааны ангиллаар/

3.4. Хуваарьт төлбөр барагдуулалтаас үүссэн алданги /Авлага, өглөг нь Хугацааны ангиллаар/

3.5 Ханшийн зөрүүний олз, гарз

Гэрээт ажил нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Энгийн, ашиглахад хялбар байх,
2. Иж бүрэн мэдээллийг тооцоолох,
3. Харилцагч тус бүрээр болон нэгдсэн байдлаар тайлагнах боломжтой байх,
3. Ойлгомжтой, тодорхой байх,
4. Шаардлагатай тооцооллууд программаар бодогдох, бодолтын дүнд гаднаас нөлөөлөх боломжгүй байх,
5. Мэдээллийг тухай бүр шинэчлэх, боловсруулсан аргачлалыг бусад төсөл хөтөлбөрүүдэд хөрвүүлэн ашиглах боломжтой томъёолол хэлбэрээр хийгдсэн байх,

Гүйцэтгэх хугацаа: 30 хоног

Оролцогч:

Хуулийн этгээд, Зөвлөх баг, Хувь хүн оролцох эрхтэй.

Бүрдүүлэх материал:

- Сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлт,
- Хүсэлт гаргагчийн танилцуулга,
- Гэрээт ажил гүйцэтгэх санхүүгийн санал,

Дэлгэрэнгүй мэдээллийг 2022 оны 05 дугаар сарын 11 -ний өдрийн 17:30 цаг хүртэл тус сангийн **77238888** болон Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Ө.Мөнхзаяа 94108868 дугаарын утсаар холбогдон авна уу.

Хугацаа:

Саналыг 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 12:00 цаг хүртэл битүүмжлэн ирүүлэх бөгөөд мөн өдрийн 12.30 цагаас хүсэлт гаргасан оролцогчдын төлөөллийг байлцуулан нээж **Бага үнийн аргаар** сонгон шалгаруулна.

Хаяг:

Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн байр, 3 дугаар давхар, 4 тоот өрөө